

Хөдөө аж ахуйн ур чадварын түвшин тогтоох шалгалт (Мал аж ахуйн ерөнхий мэдлэг)-ын шалгалтын стандартын тойм, Монгол хэлний хэвлэл

Үндэсний Хөдөө Аж Ахуйн Танхим
Хөдөө аж ахуйн ур чадварын түвшин тогтоох шалгалтын Хэрэг эрхлэх газар

1. Шалгалтын стандарт

(1) Шалгалтын үргэлжлэх хугацаа

60 минут (Үүнээс гадна, шалгалтын зааварчилгаа, дуу шалгах дэлгэц зэрэгт 10 минут)

(2) Шалгалтын сэдэв

○ Япон хэлний чадвар шалгах, үнэлгээ хийх (Япон хэлний шалгалт)

1) Япон хэлний шалгалт

Бичлэг сонсож, тоогоор бичих хэлбэрийн болон сонгох хэлбэрийн шалгалт

○ Мал аж ахуйн онолын болон практик шалгалт

1) Онолын шалгалт

Зөв бурууг олох хэлбэрийн болон сонгох хэлбэрийн шалгалт

2) Практик шалгалт

Зөв бурууг олох хэлбэрийн болон сонгох хэлбэрийн шалгалт

(3) Шалгалтын даалгаврын тоо

70 орчим асуулттай. (Зөв хариултын хувь г.м дүн шинжилгээ хийхэд ашиглагдах, шалгалтын оноонд нөлөөлөхгүй даалгавар үүнд орно.)

2. Шалгалтанд тэнцэх шалгуур

Нийт авсан оноо нь Үндэсний Хөдөө Аж Ахуйн Танхимын тогтоосон шалгуур онооноос дээш байх.

3. Тус баримт бичгийг хэрэгжүүлэх

Хөдөө аж ахуйн ур чадварын түвшин тогтоох шалгалт (Мал аж ахуйн ерөнхий мэдлэг)-ын “Шалгалтын стандарт”-ыг хэрэгжүүлэхдээ, Япон хэлээр боловсруулсан эх хувийг үндэслэн хэрэгжүүлнэ.